

## АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ МЭДҮҮЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

### 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)-ийн Ашиг сонирхлын зөрчлийг мэдүүлэх, шийдвэрлэх журам (“Журам”)-ыг Компани болон түүний охин компанийн удирдах, эрх бүхий албан тушаалтнууд, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн хооронд үүссэн болон үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчлийг тодорхойлох, сонирхлын зөрчлийг хянах, шийдвэрлэх эрх бүхий этгээдийг тодорхойлох, сонирхлын зөрчлийг зохистой шийдвэрлэх, улмаар Компанийн өнөөгийн ба ирээдүйн бизнесийн үйл ажиллагаа, эрх ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

### 1.2. Хамрах хүрээ

Компани болон түүний охин компанийн дор дурдсан этгээдүүдэд хамаарах бөгөөд тэдгээр нь энэхүү Журмыг дагаж мөрдөнө. Үүнд:

- 1.2.1. Энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч;
- 1.2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга;
- 1.2.3. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлага;
- 1.2.4. Газар, алба, хэлтэс, эсвэл нэгжийн дарга, захирал (12 болон түүнээс дээш түвшний (Level 12 and above)); болон
- 1.2.5. Ханган нийлүүлэлтийн газар, Мерчиндайзингийн газар, Дэлгүүр хөгжүүлэлтийн газар, алба, хэлтэс, эсвэл нэгжийн менежер, дарга, захирал (10 болон түүнээс дээш түвшний (Level 10 and above))  
(энэ Журмын 1.2.1–1.2.5-д дурдсан этгээдүүдийг хамтад нь “эрх бүхий албан тушаалтан”).

### 1.3. Хяналт, нэмэлт өөрчлөлт

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Аудитын хороо тухай бүр, шаардлагатай хэмээн үзсэн үедээ энэхүү Журам болон түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг батлуулахаар ТУЗ-д танилцуулах ба аливаа өөрчлөлтийг ТУЗ баталснаар хүчин төгөлдөр мөрдөнө.

### 1.4. Журмын нөхцөл

Энэхүү Журам болон Компанийн Дүрмийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд Компанийн Дүрэм давуу хүчинтэй байх ба энэ Журам нь Монгол Улсын хууль, тогтоомжтой нийцээгүй тохиолдолд сүүлд батлагдсан хуулийн зохицуулалт нь давуу хүчинтэй байна. Энэхүү Журмын заалтыг хэрхэн тайлбарлах болон тэдгээрийг хэрэглэхтэй холбогдсон зарим тодорхойгүй байдал, санал зөрөлдөөн үүссэн үед бусад ТУЗ-ийн гишүүдийн оролцоотойгоор ТУЗ-ийн даргын саналаар шийдвэрлэнэ. Энэ Журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Компанийн тухай хууль, Компанийн Дүрэм болон бусад эрх зүйн актад зааснаар шийдвэрлэнэ.

### 1.5. Нэр томьёо

Энэхүү журамд хэрэглэсэн зарим нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.5.1. “Ашиг сонирхол” гэж эрх бүхий албан тушаалтан нь албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг;

- 1.5.2. **“Бэлэг”** гэж эрх бүхий албан тушаалтанд үнэ төлбөргүй эд хөрөнгө өгөх, үйлчилгээ үзүүлэх, эрх шилжүүлэх, үүргээс чөлөөлөх болон ямарваа нэгэн байдлаар давуу байдал үүсгэх, эрх бүхий албан тушаалтан болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн тусын тулд эрхээс татгалзах зэрэг аливаа хэлбэрийн эдийн засгийн үр ашиг бүхий нөхцөл бүрдүүлсэн эд зүйл болон үйл ажиллагааг;
- 1.5.3. **“Нэгдмэл сонирхолтой этгээд”** гэж эрх бүхий албан тушаалтны эхнэр/нөхөр/хамтран амьдрагч; эцэг, эх; 18-с дээш насны хүүхэд; төрсөн ах, эгч, дүү; авга, нагац; эхнэр/нөхөр/хамтран амьдрагчийн эцэг, эх; эхнэр/нөхөр/хамтран амьдрагчийн төрсөн ах, эгч, дүү; болон дангаараа эсвэл тэдгээртэй хамтран 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг эсвэл удирдлага чиглэлийг нь тодорхойлдог аливаа ашгийн болон ашгийн бус байгууллага, хуулийн этгээдийг хамааруулан;
- 1.5.4. **“Сонирхлын зөрчил”** гэж эрх бүхий албан тушаалтны хувийн сонирхол нь эрхэлж буй албан тушаал, гүйцэтгэж буй ажил үүрэг болон компанийн ашиг сонирхолтой зөрчилдөж, албан үүргээ зүй зохистой, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг;
- 1.5.5. **“Сонирхлын зөрчилтэй хэлцэл”** гэж энэ Журмын 3-т заасан үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой хэлцлийг ойлгоно.
- 1.5.6. **“Сонирхлын зөрчилтэй үйлдэл”** гэж энэ Журмын 4-т заасан үйлдлийг гаргасан байхыг болон гаргахаар завдсаныг;
- 1.5.7. **“Хандив”** гэж эрх бүхий албан тушаалтанд тодорхой зориулалтаар, үнэ төлбөргүй, эсхүл нийтэд санал болгож байгаа хөнгөлөлтөөс илүү хөнгөлөлттэй үнээр санхүүгийн эх үүсвэр, эд хөрөнгө шилжүүлэх болон үйлчилгээ үзүүлэхийг.

## **2. ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

- 2.1. Эрх бүхий албан тушаалтан нь ажил, албан тушаалын байдал, эрх мэдлээ өөрийн хувийн ашиг сонирхолд ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц сонирхлын зөрчил бүхий аливаа харилцаанаас ангид байна.
- 2.2. Эрх бүхий албан тушаалтан нь сонирхлын зөрчлөө энэ Журмын 5-д заасан журмын дагуу мэдүүлээгүй эсвэл сонирхлын зөрчлөө нуун дарагдуулсан нь тогтоогдсон тохиолдолд (i) түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх; (ii) Компанийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасан арга хэмжээг авах; (iii) хэрэв Компанид опцион (employee share option) эзэмшдэг тохиолдолд тухайн опционыг бүхэлд нь Компанид шилжүүлж авах; ба/эсхүл (iv) үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх хүртэлх арга хэмжээг авна.
- 2.3. Эрх бүхий албан тушаалтан нь сонирхлын зөрчлөө албан ёсоор, цаг тухайд нь мэдүүлсэн байх нь түүнийг шууд буруутай үйлдлээс эс хамаарсан аливаа сөрөг үр дагаврын хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болж болох ба хэрэв ТУЗ-өөс албан ёсоор шаардсан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь холбогдох зөрчлийг арилгана.
- 2.4. Эрх бүхий албан тушаалтнаас мэдүүлсэн сонирхлын зөрчил болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдүүлэг нь хувь хүний нууцад хамаарах бөгөөд тус мэдээллийг эзэмшиж буй ажилтан, албан тушаалтан нь энэ Журам болон холбогдох бусад хууль тогтоомжид өөрөөр зааснаас бусад тохиолдолд задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
- 2.5. Эрх бүхий албан тушаалтны мэдүүлсэн сонирхлын зөрчлийг бодитой үнэлж, хянаагүйгээс гарсан аливаа сөрөг үр дагаврын хариуцлагыг ТУЗ хүлээнэ.

## **3. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ**

- 3.1. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд тухайн санхүүгийн жилд нийлбэр дүнгээр 100,000,000 (нэг зуун сая) төгрөгөөс дээш үнийн дүнтэй хэлцэлд дор дурдсан хэлбэрээр оролцохыг сонирхлын зөрчилтэй хэлцэл хэмээн үзнэ. Үүнд:
- 3.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
  - 3.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
  - 3.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
  - 3.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

#### **4. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ҮЙЛДЭЛ**

- 4.1. Эрх бүхий албан тушаалтан нь дор дурдсан үйлдлийг гаргасан болон гаргахаар завдсан тохиолдолд сонирхлын зөрчилтэй үйлдэл гаргасан хэмээн үзнэ. Үүнд:
- 4.1.1. ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй шууд өрсөлдөгч эсхүл Компанитай бизнесийн харилцаа холбоотой байгууллагад давхар ажил үүрэг гүйцэтгэх, шан харамж, тухайн байгууллагын хувьцааг нь авах;
  - 4.1.2. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд тулгуурлан дангаараа болон өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран шууд болон шууд бусаар хувийн бизнесийг хөгжүүлэх;
  - 4.1.3. Ижил төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа шууд өрсөлдөгч эсхүл Компанитай бизнесийн харилцаа холбоотой байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон түүний нэгдмэл сонирхолтой этгээд шууд болон шууд бус хэлбэрээр өмчилдөг, тус байгууллагаас шууд болон шууд бусаар ашиг, орлого хүртдэг, удирдах ажил үүрэг гүйцэтгэдэг эсхүл төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байх;
  - 4.1.4. тодорхой асуудлаар шийдвэр гаргахад ажил, албан тушаалын байдал, эрх мэдэл, танил талын хүрээгээ ашиглан шууд болон шууд бусаар нөлөөлөх;
  - 4.1.5. нэгдмэл сонирхолтой этгээддээ давуу эрх олгох;
  - 4.1.6. аливаа хэлбэрийн ашиг сонирхлын зөрчилд орж болзошгүй шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх; эсхүл
  - 4.1.7. ажиллах явцдаа олж авсан мэдээллийг зүй бусаар ашиглах буюу ашиглахыг зөвшөөрөх.

#### **5. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛИЙГ МЭДҮҮЛЭХ**

- 5.1. Эрх бүхий албан тушаалтан нь (i) энэ Журмын 3 болон 4-т заасан өөрийн ашиг сонирхлын зөрчил эсхүл болзошгүй зөрчил; болон (ii) хүлээн авсан эсхүл авахаар завдаж буй 200,000 (хоёр зуун мянган) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бэлэг, хандивын

талаар мэдүүлгийг жил бүрийн 01-р сард багтаан (шинээр эрх бүхий албан тушаалтнаар томилогдсон бол томилогдсон өдрөөс эхлэн 14 хоногт багтаан) энэ Журмын Хавсралт 1, Хавсралт 2-д заасан маягтын дагуу ТУЗ-ийн нарийн бичгийн даргад бодитой, үнэн зөв мэдүүлнэ.

- 5.2. Эрх бүхий албан тушаалтны өмнө мэдүүлсэн мэдүүлэгт өөрчлөлт орсон тохиолдолд эсвэл Компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа хугацаа харгалзахгүйгээр тухай бүр мэдүүлгийг шинэчлэн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдүүлнэ.
- 5.3. Эрх бүхий албан тушаалтан болон Компанийн бусад ажилчдад бусдын сонирхлын зөрчил, хүлээн авсан эсхүл авахаар завдаж буй 200,000 (хоёр зуун мянган) төгрөгөөс дээш үнийн дүнтэй бэлэг, хандивын талаар мэдүүлэх эрх нээлттэй байна.
- 5.4. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухайн эрх бүхий албан тушаалтан уг нөхцөл байдалд бичгээр тайлбар гаргах ба Компанид шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх үүрэг хүлээнэ.
- 5.5. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Компани тухайн сонирхлын зөрчил гаргасан байж болзошгүй эрх бүхий албан тушаалтан болон түүний нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн дансны хуулга болон бусад баримт сэлтийг гаргуулан авч харах хүсэлт тавих ба эрх бүхий албан тушаалтан болон нэгдмэл сонирхолтой этгээдүүд зөвшөөрсний үндсэн дээр танилцана.
- 5.6. Ашиг сонирхлын зөрчилтэй гэх үндэслэл бий болсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд саналын эрхгүй оролцоно.

## **6. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ХЯНАХ**

- 6.1. Журмын 5-д заасан сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хүлээж авах, холбогдох бүртгэлийг хөтлөх, хадгалах, тайланг жил бүрийн 4-р сард багтаан гаргаж ТУЗ-д хүргүүлэх, Журмын 3.1 болон 4-т заасан сонирхлын зөрчил илэрсэн тохиолдолд ТУЗ-д мэдээлж холбогдох шийдвэрийг энэ Журмын 7-д заасан журмын дагуу ТУЗ-өөр гаргуулах ажлыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцна.
- 6.2. Компанийн санхүү болон хуулийн алба, хэлтэс, нэгжийг ахалж буй ажилтнууд нь Компанийн гэрээ хэлцэл сонирхлын зөрчилтэй байгаа эсэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргын ирүүлсэн мэдээлэлд үндэслэн хянан шалгах ба аливаа зөрчил илэрсэн тохиолдолд зөрчлийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдээлж энэ Журмын 5-д заасан журмын дагуу ТУЗ-ийн шийдвэр гарсан эсэхийг баталгаажуулна.
- 6.3. Компанийн санхүү болон хуулийн алба, хэлтэс, нэгжийг ахалж буй ажилтнууд нь холбоотой талтай гэрээ хэлцэл хийх ба/эсвэл түүнд гүйлгээ гарч буй эсэхэд хяналт тавих бөгөөд Журмын 3-т заасан сонирхлын зөрчил бүхий гэрээг байгуулах ба/эсвэл гүйлгээг гаргахаас өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдээлж Журмын 5-д заасан журмын дагуу ТУЗ-ийн шийдвэр гарсан эсэхийг баталгаажуулна.

## **7. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ**

- 7.1. ТУЗ нь сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл, тайланд үндэслэн энэ Журмын 5.1.1-т заасан сонирхлын зөрчлийг үнэлэх, тухайн хэлцлийг хийх эсэх асуудлыг шийдвэрлэх ба эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээсэн эсэхээс үл хамааран энэ Журмын 2.2-т заасан хариуцлагыг ногдуулна.

**Хавсралт 1.**

**СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ МЭДҮҮЛЭХ МАЯГТ**

<b>Хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны мэдээлэл</b>	
Овог нэр:	Компанийн нэр:
Албан тушаал:	Харьяалах нэгжийн нэр:

<b>Хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны мэдүүлэг</b>	
Миний бие Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг уншиж ойлгосон бөгөөд надад сонирхлын зөрчил эсхүл болзошгүй зөрчил:-	
<b>Байхгүй</b> <input type="checkbox"/>	<b>Байгаа</b> <input type="checkbox"/> (Хэрэв байгаа бол доорх хэсгийг бөглөнө)
Миний бие дараах сонирхлын зөрчил эсхүл болзошгүй зөрчлийг мэдүүлж байна:	
1	
2	
3	
4	
5	
Миний бие дараах бэлэг, хандивыг хүлээн авсан эсхүл авахаар завдаж буйг мэдүүлж байна:	
1	Бэлэг, хандивын нэр, төрөл: _____ Үнийн дүн: _____
2	Бэлэг, хандивын нэр, төрөл: _____ Үнийн дүн: _____
3	Бэлэг, хандивын нэр, төрөл: _____ Үнийн дүн: _____

<b>Мэдүүлсэн хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны</b>	
Гарын үсэг:	Огноо:

**Хавсралт 2.**

**НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДИЙГ МЭДҮҮЛЭХ МАЯГТ**

Хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны мэдээлэл	
Албан тушаалтны овог нэр:	Компанийн нэр:
Албан тушаал:	Харьяалах нэгжийн нэр:

Хүснэгт 1. Хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд		
Нэгдмэл сонирхолтой этгээдийн	Овог, нэр	Регистрийн дугаар (заавал бичнэ)
Эхнэр/нөхөр/хамтран амьдрагч:		
18-с дээш насны хүүхэд:		
Эцэг, эх:		
Төсөн ах, эгч, дүү:		
Авга, нагац:		
Хадам эцэг, хадам эх:		
Эхнэр/нөхөр/хамтран амьдрагчийн төрсөн ах, эгч, дүү:		

Хүснэгт 2. Хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны дангаараа 20-с дээш хувийг нь эзэмшдэг компани					
Компанийн нэр, регистрийн дугаар	Эзэмшлийн хэлбэр (шууд, шууд бус)	Хамаарал (салбар, охин компани г.м.)	Эзэмшлийн хувь	Хамаатай болсон огноо	Үйл ажиллагааны чиглэл
1					
2					
3					
4					
5					

Хүснэгт 3. Дээрх Хүснэгт 1-д дурдсан этгээдүүдийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг компани			
Компанийн нэр, регистрийн дугаар	Албан тушаал	Хамааралтай болсон он, сар	Үйл ажиллагааны чиглэл
1			
2			
3			
4			
5			

Хүснэгт 4. Дээрх Хүснэгт 1-д дурдсан этгээдүүдтэй хамтран 20-оос дээш хувийг нь эзэмшдэг компани					
Компанийн нэр, регистрийн дугаар	Эзэмшлийн хэлбэр (шууд, шууд бус)	Хамаарал (салбар, охин компани г.м.)	Эзэмшлийн хувь	Хамааралтай болсон он, сар	Үйл ажиллагааны чиглэл
1					
2					
3					
4					
5					

<b>Мэдүүлсэн хувьцаа эзэмшигч/эрх бүхий албан тушаалтны:-</b>	
Гарын үсэг:	Огноо: